



Ганцаарчилсан сурвалжлагын арга

Рэймонд Жервейс

2022



Агуулга

Сэдвийн хүрээнд:

- ❖ Ганцаарчилсан сурвалжлагын аргын үндсэн ойлголт
- ❖ ГС хийх үндсэн процедурыг танилцуулна
- ❖ ГСА –г хэрэглэх давуу болон сул талууд

Ганцаарчилсан сурвалжлагын аргын тодорхойлолт

Ганцаарчилсан сурвалжлага бол чанарын арга бөгөөд сонирхсон сэдвийн талаарх анхны мэдлэгт үндэслэн сонгосон 15-35 хүнтэй өндөр чанартай, гүнзгийрүүлсэн ярилцлага хийх юм. Хэлэлцэх асуудлын жагсаалтад тулгуурлан сурвалжлагыг бүтэцлэсэн байдаг. Ярилцлага авагчид асуултуудаа зөнгөөрөө асууж, мэдээллийг олж авсны дараа сайжруулан тэмдэглэл хийдэг.

ГЯ хийхдээ ихэвчлэн оролцогч талуудын нарийн шинжилгээнээс эхэлдэг.

Ганцаарчилсан сурвалжлага яагаад хэрэгтэй гэж?

- ГСА нь хөгжлийн үйл ажиллагааны бүх үе шатанд хэрэгцээтэй- хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх. Жишээ нь: төслийн дизайнд нөлөөлж болох гол үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх боломжтой. Эсвэл үр ашиг хүртэгчид төслийн санал болгож буй үйлчилгээг яагаад ашиглахгүй байгааг ч тайлбарлаж магадгүй юм.
- Мэдээллийг хурдан цуглуулах боломжтой тул шийдвэр гаргагчдад хэрэгтээтэй.
- ГСА нь түншүүд, удирдагчид болон бусад чухал оролцогч талуудын хүсэл эрмэлзэл, зан байдал, хэтийн төлөвийг ойлгоход тусалдаг.
- Зарим гол мэдээлэгчид хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулах зөвлөмжийг боловсруулахад тусалж чадна.

Ганцаарчилсан сурвалжлага яагаад хэрэгтэй гэж? (үргэлжлэл)

- Өгөгдөл/мэдээлэл цуглуулах бусад аргуудыг ашиглах үед тэд өөрсдийн мэдээллийн үнэн зөв байдал, тэдгээрийн нөхцөл байдал (жишээлбэл, хүн амын тооллого), тэдгээрийн шинжилгээний давуу болон сул талууд болон эх сурвалжид нөлөөлж буй бусад чухал хүчин зүйлүүдийг үнэлэх боломжтой..
- Тэд ямар бэрхшээлээс зайлсхийх, аль эрсдэлийг бууруулах талаар мэдээлэх замаар тоон аргуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна.

ГС хийх алхамууд:

Алхам 1: Судалгааны асуултуудыг боловсруул. Тэдний тоо (5-аас ихгүй) хязгаарлагдмал байх ёстой, учир нь "чухал" хүмүүст ярилцлага өгөх цаг бага байдаг.

Алхам 2: Ярилцлагад зориулсан товч удирдамж бэлтгэ. Энэ нь уян хатан, удирдах боломжтой байх ёстой (хамгийн ихдээ 12 сэдэв). Удирдамжид судалж буй асуудал бүрийн хүрээнд авч үзэх үндсэн сэдэв, асуултуудыг жагсаасан байх ёстой.

Алхам 3: Мэдээлэгчийг сонго. Гол мэдээлэгчийг тухайн сэдвийн талаархи мэдлэг, үзэл бодолд тулгуурлан сонгох ёстой. Төлөвлөгчид өөр өөр үзэл бодолтой мэдээлэгчийг сонгоход анхаарах хэрэгтэй (оролцогч талуудын шинжилгээг харах).

Алхам 4: Ярилцлагыг анхааралтай хийх: Ярилцлагын зорилгыг тайлбарлаж эхлэх; нууцлал эсвэл зөвшөөрлийг баталгаажуулах; асуултуудын логик дараалал; дараагийн асуултаар бататгах аргыг ашиглах, дэлгэрэнгүй мэдээллийг хайх; төвийг сахисан байр суурь барих; орчуулга, хэлний бэрхшээлийг аль болох багасгах.

ГС хийх алхамууд: (үргэлжлэл)

Алхам 5: Тэмдэглэл хөтлө. Ярилцлага бүрийн дараа тэмдэглэл бичиж, хяна.

Алхам 6: Ярилцлагын хураангуй хуудсаар ярилцлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх; боломжтой бол тайлбарлах кодууд үүсгэх; мэдээллийг хадгалах, сэргээх энгийн системийг хөгжүүлэх.

Алхам 7: Өгөгдлийн танилцуулга. Хүснэгт, блок, зураг гэх мэт визуал хэлбэрээр мэдээллийг үзүүлж, гол холбоос, чиг хандлагыг тодотгож өгнө. Энэ нь шийдвэр гаргагчдад ярилцлагын үр дүнг илүү ойлгомжтой, хурдан, хялбар хүргэхэд тусалдаг.

Алхам 8: Гол мэдээлэгчийг шалгах замаар найдвартай, хүчинтэй мэдээлэл өгч чадах эсэхийг нягтлана уу (түүвэрт эмэгтэйчүүд байгаа юу?); гол мэдээлэгчийн найдвартай байдлыг үнэлэх; ярилцлага авагч эсвэл шалгагчийн алдаа орсон эсэхийг шалгах; мэдээлэгчдээс санал хүсэлтийг хүлээн авах

Ганцаарчилсан сурвалжлагын давуу талууд

- Нягтлан тодруулах боломжтой
- Хариулт авах өндөр магадлалтай
- Нарийвчилсан мэдээлэл цуглуулж, таамаг дэвшүүлэх боломж
- Чухал үүрэг гүйцэтгэсэн хүмүүсээс мэдээлэл цуглуулж чаддаг
- Тодорхой хүмүүст (олон нийтийн төлөөлөл, шийдвэр гаргагчид) хүрэхэд илүү хялбар байдаг.
- Илүү хувь хувийн шинж чанартай
- Хялбар нээлттэй асуулт асуух, лавшруулах, биеийн хэлэмжээр хариуг ойлгоход амар байдаг.

Ганцаарчилсан сурвалжлагын сул талууд:

- Хариу үйлдлийн нөлөө: ярилцлага авагчийн байр байдал, характер нь үр дүнг гажуудуулж болзошгүй (хүйсийн хариу үйлдэл).
- Өөр өөр байршилд олон чиглэлийн ярилцлага хийхэд өндөр өртөгтэй байж болно.
- Ярилцлага хийх нь ур чадвар шаарддаг. Суралцах хэрэгтэй (үндсэн эсвэл гүнзгийрүүлсэн сургалт)
- Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх хамгийн удаан арга
- Хариултууд нь шударга бус, бодлогогүй байж болно
- Ярилцлага авагч нь цагийн хуваараа сайтар тохиролцож, очих ёстой.
- Нэрээ нууцлахыг илүүд үздэг оролцогчидод ийм ярилцлага тухгүй, таалагдахгүй байж магадгүй
- Үр дүнд дүн шинжилгээ хийж, тоон үзүүлэлтийг гаргахад хэцүү

“ Баярлалаа “





In partnership with
Canada



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000